


Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын  
11-ний өдрийн 255 дугаар тогтоолоор баталсан  
"Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт маягт 2

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 6 сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Ард Санхүүгийн Нэгдэл ХК, 9010001145, РД: 2001861, MSE:AARD, 77003322
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Санхүү, хөрөнгө оруулалт
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	28,614,263
Улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Комплайнс эрхэлсэн захирал Ө.Ашхүү Гүйцэтгэх захирал Б.Золбоо
<p>1. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</p>	
Санхүүгийн байдлын үзүүлэлт	2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав.
Орлогын тайлан	2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав.
Өмчийн өөрчлөлтийн тайлан	2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав.
Мөнгөн гүйлгээний тайлан	2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав.
<p>2. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөвлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</p>	

2024 оны 7 сарын 30-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны ээлжит хурлаар компанийн хагас жилийн тайланг хэлэлцэж баталгаажуулна.			
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>		
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа Эргэлтийн хөрөнгийн харьцаа Эргэлтийн хөрөнгө, нийт хөрөнгөд харьцах харьцаа	1.23 1.33 0.4
3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгий нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Нийт хөрөнгийн өгөөж (ТТМ) Өөрийн хөрөнгийн өгөөж (ТТМ) Цэвэр ашгийн маржин	4.05% 6.88% 80.8%
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	Компанийн хагас жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж, цахим хуудсанд байршуулав.	
3.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i>	Байхгүй	
4.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>		
Их хэмжээний хэлцэл: Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно. Сонирхлын зөрчилтэй хэлцэл. 2024 оны 1-р улиралд: <ol style="list-style-type: none"> <li>Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д 500 сая төгрөгийг 2 сарын хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.01.26</li> <li>Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д 100 сая төгрөгийг 7 хоногийн хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.02.09</li> <li>Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д 850 сая төгрөгийг 7 хоногийн хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.02.14</li> <li>Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д 500 сая төгрөгийг 1 сарын хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.03.05</li> </ol> 2024 оны 2-р улиралд: <ol style="list-style-type: none"> <li>Ард Санхүүгийн Нэгдэл ХК-нд 300 сая төгрөгийг 2 сарын хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.04.03</li> </ol>			
5.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжисж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i>		
Байхгүй болно.			
6.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>		

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь компанийн зохистой засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааг нээлттэй ил тод явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагыг болон бусад оролцогч талуудын хоорондох харилцааг засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэнт ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурал: 2024 оны 4 сарын 27-ны өдөр Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг амжилттай зохион байгуулсан. Тус хурлаар Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны Аудитлагдсан тайлан батлах, ТУЗ-ийн төсвийг батлах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн Удирдах зөвлөл: 2024 оны 4 сарын 25-ны өдөр Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ нь нэг удаа ээлжит хурал, нийт таван удаа эчнээ санал хураалт явуулсан байна.

Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан тогтоол, шийдвэрүүдийг хууль журмын хүрээнд олон нийтэд мэдээллэж ажиллалаа.


7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

СЗХ-оос 2024 оны 01 дүгээр сард ирүүлээд байсан "Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилтийн үнэлгээний хянан баталгаажуулалтад заасан үүрэг, даалгаврыг биелүүлж, холбогдох материалыг хавсарган журмын хугацаанд илгээсэн болно.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Золбоо

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....  


Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ө.Ашхүү

Албан тушаал: Комплайнс эрхэлсэн захирал

Гарын үсэг: .....  
